



Шувууны сангасаар бордоо хийх технологи

Шувууны сангасыг эсгэж бордоо хийх

Ургамлын амьдралд нэгийг нь нөгөөгөөр нь орлуулж болохгүй 5 хүчин зүйл байдгийн нэг нь шим тэжээлийн бодис юм. Шим тэжээлийн бодисыг бордоогоор өгнө.

Ургамал ургах явцдаа хөрсөнд шим тэжээлийн бодис болох макро болон микро элементүүдээр хооллодог. Иймээс ургамалд хэрэгцээтэй элементүүдийг бордоогоор нөхөж өгөх бөгөөд талбайгаа жил бүр тохирсон тунгаар бордох шаардлагатай.

Хөрсний үржил шим ядуурах нь таримлын ургац буурах үндсэн хүчин зүйл болдог. Иймд хөрсний үржил шимийг сайжруулахад зориудаар ургацыг нэмэгдүүлэх арга хэрэглэдэг. Таримал ургамалд ашиглагдах тэжээлийн бодисын агууламж сайтай, байгалийн цэвэр бордоо болох “Шувууны сангас”-ыг ашиглан бордоо хийх технологийг танилцуулж байна.

“Шувууны сангас” нь азот, фосфор, кали зэрэг ийм тэжээлийн бодис ихтэй нянгүй бодисоор баялаг байдаг. Ховд аймгийн Буянт голын сав дагуух ногоочид байшингийн дээвэр дээрхи шувууны сангасыг цуглуулан хүнсний ногоогооны талбайгаа бордож ургацаа нэмэгдүүлдэг уламжлалтай

Шувууны сангасаар исгэсэн бордоог бэлтгэхдээ төмөр болон модон торх бэлтгээд 50 литр усанд 5-6 кг сангас хийнэ. 7 хоног торхнийхоо амыг даавуу, нийлэг уутаар сайтар таглан исгэнэ. Уусмалыг бүрэн иссэний дараа торхонд 50 литр ус нэмж 100 литр шингэн бордоо бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэсэн шингэн бордоог хүнсний ногооны талбайд хэрэглэхэд ургацыг 25 – 30 хувь нэмэгдүүлдэг.

1-р зургийн тайлбар: Сангасыг исгэж буй байдал

2-р зургийн тайлбар: Сангасаар бордсон талбайн зураг



Байршил: Ховд аймаг Буянт, Ховд сум

Технологийн хамрах хүрээ:

Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Агрономийн

Газар ашиглалтын төрөл: Тариалангийн газар

Уур амьсгал: Хуурай, сэрүүн

MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: TA MOH-12

Холбогдох арга барил: бүртгэгдээгүй

Технологийг нэвтрүүлсэн: орон нутгийн тариаланчид

Технологийн талаархи мэдээллийг өгсөн: М.Даваадорж

Технологийг бүртгэсэн: М.Даваадорж

Он, сар, өдөр: 2008.07.07

Эмхэтгэгчдийн тайлбар: Энэхүү уламжлалт технологийг жижиг тариалангийн талбай бүхий хүнсний ногооны талбайд өргөн ашиглаж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлдэг. Бид ховд аймгийн тариаланчдын жишээгээр энд оруулав.

Ангилал


Газар ашиглалтанд тулгарч буй асуудал: Тариалангийн газрын бүтээмжийг сайжруулахад чиглэгдсэн ажлууд хоцрогдож харин хэрхэн, яаж арвин ургац авах асуудал ард иргэдийн дунд давамгайлах болсон. Ингэснээр хөрсний үржил шимийг бууруулж, органик бус химийн бордоог ашиглах нь олширсон.


Газар ашиглалт	Уур амьсгал	Доройтлын хэлбэр	Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл
 <p>Тариалангийн газар</p> <p>ар</p>	 <p>Хуурай сэрүүн</p>	  <p>Биологийн доройтол: биомасс буурсан</p> <p>Салхины элэгдэл</p>	 <p>Ургамал газар тариалангийн</p>
<p>Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрсний үржил шим нэмэгдсэн - Ургац нэмэгдсэн 			<p>Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> - Шим бордоо хийх мэдлэг нэмэгдсэн - Амжиргаа сайжирсан

Байгаль орчин

Дундаж хур тунадас (мм)	Өндөршил (д.т.д м)	Гадаргын хэлбэр	Налуужилт (%)
 <p>>500 400-500 300-400 250-300 200-250 150-200 100-150 50-100 <50</p>	 <p>>4000 3500-4000 3000-3500 2500-3000 2000-2500 1500-2000 1000-1500 500-1000 <250</p>		 <p>Маш эгц (>60) Эгц (30-60) Налуу (16-30) Долгиот (8-16) Дунд зэрэг (5-8) Бага зэрэг (2-5) Тэгш (0-2)</p>
<p>Хөрсний гүн (см)</p>  <p>0-20 20-50 50-80 80-120 <120</p>	<p>Ургамал ургах хугацаа: 120-140 өдөр Хөрсний үржил шим: Дунд зэрэг Хөрсний бүтэц: Чулуурхаг Гадаргын чулуурхаг байдал: Жижиг ширхэгтэй хайрга Гадаргын органик бодисын хэмжээ: Дунд Хөрсний ус нэвтрүүлэх чадвар: Сайн Хөрсний элэгдэл эвдрэлд өртөх байдал: Дунд</p>		<p>Агаарын жилийн дундаж температур: -0.5 C° Хамгийн их/бага температур: +35/-48 Агаарын хамгийн их/бага даралт: 4 сард 901.5/мб/, 3сард 832.2 /мб/ Агаарын жилийн дундаж даралт: 860.5 /мб/ Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа: Жилд 2794 цаг, 5-6 р сар буюу хамгийн ихдээ 290 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 142 цаг байдаг байна.</p>

Нийгэм-эдийн засаг

Нэг өрхөд ногдох тариалангийн талбай (га)	Газар ашиглалтын эрх:	Суурин/нүүдэлчин:
 <p>>1 1-2 2-5 5-15 15-50 50-100 100-500 500-1000 1000-10000 <10000</p>	<p>Газар эзэмшсэн эсэх: Төрийн/нийтийн Зах зээлийн төрөлжилт: Холимог: амь зуулга/арилжаа наймаа Шаадагдах техник мэдлэг төвшин: Бага: Газар ашиглагч ХАА-аас гадна олох орлого, түүний ач холбогдол: 20%</p>	<p>Ядуурлын төвшин: Бага Ажилгүйдлийн төвшин: Дунд Нигмийн зохион байгуулалт: Сайн</p>



Техникийн зураг:

1. Бордоог хийхэд шаардлагатай сангас, усны хэмжээ
2. Сангасыг цуглуулах болох байрлал

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Үйл ажиллагааны дараалал	Байгуулахад гарах зардал /1 худаг гаргахад/, 1 \$-ыг 1000 төгрөгөөр бодов.		
	Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. 4-р сард шувууны сангасыг цуглуулж бэлдэнэ			
2. Цуглуулсан сангасаа хучиж хадгална.			
3. Торхоо бэлдэнэ.			
4. 6,7,8-р сард исгэж бордоно.			
5. Таримлын ургалтын хугацаанд нэмэлт бордоо болгон өгнө.			
	Сангас цуглуулах/2 хүн, нэгжийн үнэ 5000 ₮	10	100%
	Тээвэрлэх /30 л, нэгжийн үнэ 1470 ₮	44	100%
	Торх /3 ш, нэгжийн үнэ 15,000 ₮	45	100%
	Бордоог ургамалд цацах /1 хүн /өдөрт 10,000 ₮	10	100%
	Нийт	109	100%

Хүн хүчний өртөг	Бусад хөрөнгө оруулалт
Их	Их
Дунд	Дунд
Бага	Бага

Сангасыг иссэн үед нь ургамлын ургалтын үед усалгаа бүрд нь өгнө. хөрсний үржил шимээс хамаарч нормыг тогтооно. Хүнсний ногооны талбайн хэмжээ ихэвчлэн 6-10м/квадрат байдаг учир 10 литр иссэн сангасаар бордоно. Дулаан байвал сангас сайн исэлдэн хурдан хугацаанд ургамалд ашиглагдана.

Засаж, сайжруулах үйл ажиллагаа	Урсгал зардал 1жилд /га-аар/		
	Гарах зардал	өртөг (US\$)	ГА-аас гарах %
1. Бордооны хэмжээг ихэсгэх зорилгоор ус, сангасны хэмжээг тохируулан хольж, нэмэлт байдлаар хийж болно.			
	Сангас, усны холимог	20	100%
	Нийт	20	100%

Үнэлгээ

Үр ашиг /газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг	ээрэг	ээрэг
	Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг	ээрэг	ээрэг

Технологийн нөлөөлөл	
Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг	Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> Ургац нэмэгдсэн	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> үгүй
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/> Тариаланчдын хийдэг үйл ажиллагаа хялбаршсан	
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/> Гарах зардал багассан	
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> Ашиг орлого нэмэгдсэн	
Нийгэм соёлын үр ашиг	Нийгэм соёлын алдагдал
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/> Хүнсний аюулгүй байдал сайжирсан	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> үгүй
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/> Хамгаалал доройтлын талаарх мэдлэг нэмэгдсэн	
Экологийн үр ашиг	Экологийн алдагдал
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> Ургацын хэмжээ нэмэгдсэн	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> үгүй
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> Хөрсөн бүрхэвч сайжирсан	
<input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> Ургац хураалт хугацаандаа	
Дам үр ашиг	Дам сул тал
<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> үгүй

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах	Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах
Урацыг 25-30% нэмэгдүүлдэг → тус технологийг улам боловсронгуй болгох шаардлагатай	Бордооны тун ихэдвэл ургамалд аюултай → бордоог зөв хэрэглэх шаардлагатай
Ус ашиглалтыг бууруулдаг → химийн бус бордоог ихээр хэрэглэх	
Ургалтыг түргэсгэдэг →	

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn